



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/166

Мөрөн сум

Хурдан морины бүсийн уралдаан  
товлон зарлах, зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, 17.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Морин спорт уяачдын холбоо, холбогдох сумын Засаг даргын саналыг тус тус харгалзан аймгийн Зүүн бүсийн сумдын хурдан морины уралдаан (бага 3 нас, сонгомол бага нас, дунд нас)-ыг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Тариалан суманд, Шишгэд бүсийн хурдан морины уралдаан (бага 3 нас)-ыг 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улаан-Уул суманд, Хойд бүсийн хурдан морины уралдаан (бага 3 нас, сонгомол бага нас, дунд нас)-ыг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Алаг-Эрдэнэ суманд, Идэр бүсийн хурдан морины уралдаан (дээд 3 нас, сонгомол дээд нас)-ыг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Төмөрбулаг суманд, Баруун бүсийн хурдан морины уралдаан (дээд 3 нас, сонгомол дээд нас)-ыг 2022 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Арбулаг суманд тус тус аймгийн бүсийн зэрэглэлтэй зохион байгуулсугай.

2. Бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулагчийн зүгээс онцгой анхаарч холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж, аливаа хураамж, бооцоо авахгүй зохион байгуулахыг Алаг-Эрдэнэ, Арбулаг, Тариалан, Төмөрбулаг, Улаан-Уул сумын Засаг дарга, аймгийн Морин Спорт уяачдын холбоо, сумдын салбар холбооны удирдлага нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН